



“Улаанбаатарзам засвар арчлалтын газар”
ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 4 дугаар сарын
27 өдрийн 4/15 дугаар тушаалын 3 хавсралт

**АЖИЛТНЫ НИЙГМИЙН АСУУДАЛ, ТЭТГЭМЖ ТУСЛАМЖ,
ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ТУХАЙ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгууллагын ажилтнуудын ур чадвар, ажлын үр дүн, ажил албан тушаал, хувийн нөхцөл байдал, нийгмийн баталгааны онцлогийг харгалзан ажил олгогчоос ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, тэтгэмж тусламж үзүүлэх, ажлын үр дүнг үнэлж шагнаж урамшуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журамд Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн тэтгэмж тусламж, шагнал урамшууллын хэмжээ, ажилтны нийгмийн асуудлыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, газрын даргын тушаалаар өөрчлөлт оруулна.

1.3 Журмын хэрэгжилтэд Захиргаа, удирдлагын хэлтэс хяналт тавьж ажиллана.

ХОЁР. ТЭТГЭМЖ ТУСЛАМЖ

2.1 Ажилтан тэтгэмж, буцалтгүй тусламж хүссэн өргөдөлдөө шалтгаанаа тодорхой бичиж, холбогдох баримт бичгийг өргөдөлдөө хавсаргаж харъяа хэлтэс, албаны даргаар цохилт хийлгэн, Захиргаа, удирдлагын хэлтэст уламжилна. Газрын дарга өргөдөл хүсэлтийг үндэслэн тушаал гаргаж тэтгэмж, буцалтгүй тусламж олгоно.

2.2 Ажилтанд дараах тохиолдолд тэтгэмж, буцалтгүй тусламж үзүүлнэ. Үүнд:

2.2.1 Ажилтны гэр бүлд шинэ хүн мэндэлсэн бол 300.000 /гурван зуун мянга/ төгрөг,

2.2.2 Ажилтан анх удаа гэр бүл болж хурим хийвэл 500.000 /таван зуун мянга/ төгрөг,

2.2.3 Ажилтны 16-аас доош насны хүүхдүүдэд Шинэ жилийн баяр болон Эх үрсийн баяраар бэлэг,

2.2.4 Ажилтаннаас барсан бол ар гэрт нь 1.000.000 /Нэг сая / төгрөг

2.2.5 Эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд, төрсөн эцэг, эхнаас барсан бол 500.000 /Таван зуун мянга/ төгрөг

2.2.6 Байгууллагын ажилтнуудад жилд нэг удаа түлээ, нүүрсний хөнгөлөлт олгож болно.

2.2.7 Байгууллагаас гавъяаны амралтаа авсан өндөр настан нас барсан бол ар гэрт нь 200.000 /хоёр зуун мянга/ төгрөг



2.2.8 Ажилтан гэнэтийн яаралтай хүнд хагалгаа, эмчилгээ хийлгэсэн тохиолдолд холбогдох баримтыг нь үндэслэн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж мөнгөн тусламж,

2.2.9 Тус газраас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг Сар шинийн баяр болон Ахмадын баярын өдрөөр хүлээн авч хүндэтгэл үзүүлж болно.

2.2.10 Ажилтныг байр орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон холбогдох дээд байгууллагад уламжилж өгөх, квотоор ирсэн орон сууцанд хамруулж, хөнгөлөлт үзүүлж болно.

2.2.11 Ажилтны өөрийн гэр бүл, орон байр нь гал түймэр, үер усны аюул зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлд нэрвэгдсэн онцгой байдлын дүгнэлт холбогдох баримт бичгээ бүрдүүлсэн тохиолдолд 500.000 /Таван зуун мянга/ төгрөг хүртэл,

2.2.12 Газарт 2-оос дээш жил тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтанд магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлагагарсан болон магистр, докторын сургалтанд хамрагдах болсон, ажилтан өөрөө болон гэр бүлийн гишүүн удаан хугацаагаар өвдсөн тохиолдолд холбогдох баримтыг нь үндэслэн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, зардлын зохих хувийг олгож болно.

2.2.13 Өрх толгойлсон эмэгтэй ажилтан 3-аас дээш хүүхэдтэй бол байгууллагаас жилд нэг удаа нэг хүүхдийн хичээлийн хэрэгслийг олгоно.

2.2.14 Шинээр ажилд орсон ажилтан 3 сараас доошгүй хугацаагаар ажилласны дараа буцалтгүй тусламж, тэтгэмж авах эрх үүснэ.

2.2.15 Ажилтанд буяны ажлын үед нь хүн хүчний болон унааны дэмжлэг үзүүлж болно.

2.3 Дараах үндэслэлээр ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилтанд газарт ажилласан хугацааг харгалзан албан тушаалын 3 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгоно. Үүнд:

2.3.1 Эрүүл мэндийн шалтгаанаар албан ажлаа гүйцэтгэх чадваргүй болж, 3 сараас доошгүй хугацаагаар эмчлүүлэн, сувилуулах шаардлагатай болсон нь тогтоогдсон

2.3.2 Ажил үүргээ гүйцэтгэж байгаад гэмтэж бэртсэний улмаас 3 сараас доошгүй хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай болсон нь эмнэлгийн магадлагаагаар тогтоогдсон бол

2.3.3 Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн

2.4 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвар алдсан бол өөрт нь, нас барсан бол ар гэрийнхэнд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэгт заасан хэмжээгээр нөхөн төлбөрийг нэг удаа олгоно.

ГУРАВ.ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

3.1 Газрын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээс хамааран Газрын даргын зөвлөлөөс гаргасан шийдвэрээр, хэлтэс, алба болон ажилтнуудад ажлын үр дүн, үнэлгээг нь үндэслэн жилд нэг удаа мөнгөн шагнал, урамшуулал олгож болно.



3.2 Газарт өөрийн нөөц бололцоогоо ашиглан эдийн засгийн хэмнэлт гаргасан, их хэмжээний орлого оруулсан, богино хугацаанд өндөр бүтээлтэй ажил үүрэг гүйцэтгэсэн ажилтанд газрын даргын шийдвэрээр урамшуулал олгож болно.

3.3 Баяр наадмын болон бусад тэмдэглэлт өдрүүдэд ажлын үр дүн, газарт оруулсан хувь нэмрийг нь харгалзан ажилтанг дараах хэлбэрээр шагнаж урамшуулна. Үүнд:

3.3.1 Мөнгөн шагнал олгох,

3.3.2 Эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах

3.3.3 Бусад байгууллага, Засгийн газрын болон төрийн дээд одон медальд нэр дэвшүүлэх

3.3.4 Бусад

3.4 Шагналд нэр дэвшүүлж байгаа ажилтны тодорхойлолт, хэлтэс, албаны хурлын тэмдэглэлийг Захиргаа, удирдлагын хэлтэс хүлээн авч, газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

3.5 Шагнуулах ажилтанг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж тодорхойлсон байх бөгөөд газрын даргын тушаалаар баталгаажуулна.

3.6 Сахилгын шийтгэл хүчинтэй байх хугацаанд энэхүү журамд заасан шагнал, урамшууллыг олгохгүй.

3.7 Энэ журмыг баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.

-ооо-